

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024.01.10

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, яамны удирдлагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.**

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

**Гурав. Үнэлэлт.**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт гэсэн 5 үзүүлэлтээр 112 арга хэмжээг дүгнэж 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 87.4 хувьтай байна.

**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц**

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан нийт 38 арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
38	90.2	25	7	2	2	2	-	-

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хангалтгүй хэрэгжилттэй болон бүрэн хэрэгжээгүй 30, 50, 70 хувиар үнэлэгдсэн дараах 6 арга хэмжээ байна.

**“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:**

1. Арга хэмжээ: 1.1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээврийн ажлыг оновчтой, аюулгүй зохион байгуулах

Зорилтот түвшин: Жилийн эцсийн байдлаар: Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 5.0 сая.тн ачаа тээвэрлэнэ.

Хэрэгжилт: 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1,736,220.15 тонн ачаа тээвэрлэж төлөвлөгөөний биелэлт 34.72 хувийн биелэлттэй байна. Тээвэрлэлтийн чиглэлээр нь авч үзвэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 527,678.62 тонн ачаа тээвэрлэж

17,23 хувь, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 1,208,541.52 тонн ачаа тээвэрлэж, тус чиглэлийн төлөвлөгөөний биелэлт 62.34 хувь байна. Тээвэрлэсэн ачааны төрлөөр нь авч үзвэл:

Экспортын чингэлэгтэй нүүрс боомтоор:

- Гашуунсухайт боомтоор-439,482 тонн

- Бусад (МТЛ) боомтоор -650,078 тонн

Дотоодын эрчим хүчний нүүрс тээвэр /мидлинг/:

- Тавантолгой түлш ХХК-378,095 тонн

- Цемент шохой ТӨХК-17,607 тонн

Нефтийн бүтээгдэхүүн:

Шунхлай ХХК- 46,469 тонн.

II. Арга хэмжээ: 8.4. Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах.

*Зорилтот түвшин:* IV улирал: Цалингийн систем төмөр замын бусад ААН-тэй өрсөлдөхүйц хэмжээнд нэмэгдэж, ажилтны сэтгэл ханамж дээшилнэ.

*Хэрэгжилт:* Компанийн 2023 оны бүтэц, орон тооны шинэчлэлийн төслийг боловсруулан энэ оны 03 дугаар сарын 27-ны өдрийн захирлын зөвлөлийн хуралд урьдчилсан байдлаар танилцуулж, дахин боловсруулах үүрэг өгсөн. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох үүргийн дагуу компанийн бүтцийн төслийг боловсруулан, ЗТХЯ-нд энэ оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 1/1383 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/28 тоот тушаалаар Компанийн “Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм”, мөн оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/61 тоот тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

Ажилтнуудын хөгжлийг дэмжих, карьер хөгжлийн төлөвлөлтөө хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Карьер хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн гаргах вэ?” сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж, 39 ажилтан хамрагдсан. 2023 оны 11 дүгээр сарын тайлангийн гүйцэтгэлээр батлагдсан орон тоо 883, одоо ажиллаж байгаа 675 байна.

Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой 2023 оны III улирлын байдлаар харьяа нэгжийн захиалгын дагуу нийт 46 ажиллах хүчнийг шинээр ажилд авсан байна.

Цалингийн ангилал, албан тушаалын зэрэглэлийг 2022 оны А/09 дүгээр тушаалаар баталсан цалингийн шатлалыг одоо мөрдөж байгаа бөгөөд Гүйцэтгэх захирлын 2023 оны А/121 дүгээр тушаалаар ажилтнуудын хөдөлмөрийн норм цалин хөлсний хэмжээг хөдөлмөр зарцуулалт тээврийн тарифтай нийцүүлж тогтоох ажлын хэсгийг байгуулан ажиллаж дүнг компанийн ТУЗ-д танилцуулахаар бэлтгэсэн. Ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2023 оны А/65 дугаартай “Удаан жилийн нэмэгдэл олгох журам” батлагдаж, 09 дүгээр сард нийт 403 ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгосон.

**“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:**

I. Арга хэмжээ: 1.2. Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, гэрчилгээжүүлэх

*Зорилтот түвшин:* Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Нийт 16 ширхэг зүтгүүр, 360 ширхэг вагоныг хүлээн авч гэрчилгээжүүлнэ.

SD70Ace серийн 2 илчит тэрэг нийлүүлэгдэж туршилтын аялал эхэлсэн байх.

*Хэрэгжилт:* Ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-тай байгуулсан ЕРС гэрээний хүрээнд нийлүүлэгдэх 16 зүтгүүрийг 2023 оны 11 дүгээр сарын 02-ны BI-TTGS-LTR-4994-00 тоот албан бичгээр эхний ээлжийн 2 зүтгүүр 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр нийлүүлэгдэж, дараагийн ээлжийн 14 зүтгүүрийг 2024 онд багтаан үе шаттайгаар нийлүүлэх тухай албан тоотыг ирүүлсэн.

SD-70Ace/LW загварын зүтгүүрийн эхний 2 нэгж зүтгүүрийн нийлүүлэлтийн явц, зүтгүүр үйлдвэрлэгчийн зүгээс ирүүлсэн сургалтын хөтөлбөрийн хамт “Бодь Интернэшнл” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн BI-TTGS-LTR-5097-00 дугаартай албан бичгээр ирүүлсэн. ЕРС гэрээний Багц-5 [Хөдлөх бүрэлдэхүүн]-д заасан нийт 812 ширхэг ачааны вагоныг хүлээн авч, одоогийн байдлаар хагас вагон 400, тавцант вагон 390, хашлагатай тавцант вагон 13, битүү вагон 8, GСУ-300K загварын 1ш өөрөө явагч зорчигчийн хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээн

авсан. Хүлээн авалтын нийт гүйцэтгэл явц 100%-тай байна. Түүнчлэн 811 вагоны хувийн дугаар болон Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой 812 вагоны объектын гэрчилгээг ГТХЗНТ-с авсан.

*Жич: Хугацаа хойшлогдож байгаа шалтгаан нь үйлдвэрлэгчийн материалын нийлүүлэлтийн саатал болон ажиллах хүчний хомсдол зэрэг бодит шалтгаантай байгаа талаар тус албан бичигт дурдсан байна.*

II. Арга хэмжээ: 5.3. Тээврийн нэгдсэн цахим программ хангамжийн худалдан авалт, компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

*Зорилтот түвшин:* III-IV улирал: Программ хангамжийн худалдан авалт хийгдэж, тээврийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.

*Хэрэгжилт:* Компанийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн дэд бүтцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, түргэн шуурхай болгох, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх талаар ажлын даалгавар, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Гүйцэтгэх захирлын 2023 оны А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан. Программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/284 дүгээр тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцүүд байнгын ашиглалтад орсонтой холбогдуулан төмөр замын байгууллагууд тээврийн бичиг баримт, мэдээллийг харилцан дамжуулах, төлбөр тооцооны болон ачаа тээврийн захиалгын программ хангамжийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд “МТЗ” ТӨХК, “ТТЗ” ХХК болон “МТЛ” ХХК нар хамтран зардлыг тэнцүү хуваан төлөх нөхцөлтэйгөөр нэгдсэн байдлаар программ хангамжийг шинээр хийлгэх, хөгжүүлэх ажлын даалгаврыг Ажлын хэсгээр дамжуулан “УБТЗ” ХНН-т хүргүүлсэн. Компанийн зүгээс ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ажлын хэсэгт цахимаар хүргүүлж, хариу шийдвэр, дүгнэлтийг хүлээж байна.

#### **“Хэрэгжих шатанд” буюу 70 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:**

I. Арга хэмжээ: 2.4. Гашуунсухайт-Ганцмод боомтын 7.9 км төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх.

*Зорилтот түвшин:* Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулна. Барилгын ажлыг 30 хувьд хүргэнэ.

*Хэрэгжилт:* Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд:

- Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөл болон зөвлөлөөр хэлэлцүүлж нийт 77 зөвлөмж авч засан, сайжруулсан. Ийнхүү 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөлөөр орж дэмжигдсэн.

- Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Төмөр замын холболтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсэг БНХАУ-ын талтай цахимаар, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод тус тус хуралдсан.

- Цахим уулзалтаар талууд тохиролцсоны дагуу Хятадын талаас хэлэлцээрийн анхны төслийг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн.

Төслийн гүйцэтгэл:

Төмөр замын чиг тогтоох 90%;

Суурь судалгааны урьдчилсан ажил 100%;

БОНБУ, Археологи, Палеонтологи, Түүх угсаатны ажил 50%;

Хээрийн судалгааны ажил 55%;

Иж бүрэн зураг төсөл боловсруулах ажил 30%-тай тус тус хийгдсэн.

Нарийвчилсан зураг төслийн инженер-геологи болон инженер геодезийн хээрийн судалгааны ажлыг төслийн талбайд гүйцэтгэж 55 хувийн гүйцэтгэлтэй байна. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлыг

яаралтай дуусгаж, барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөөг урьдчилсан байдлаар Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

БНХАУ-ын Чайна Энержи Баошөн төмөр зам группийн Гүйцэтгэх захирал Бизнь Липингийн урилгаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан гүүрэн байгууламжийг хамтран барих үеийн техникийн нөхцлийг тохиролцох, Хятадын талд байгаа төмөр замын нөхцөл байдлыг газар дээр нь танилцаж албан уулзалт хийх зорилгоор “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Будбаяр өөрийн байгууллагын удирдлагуудын хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотод албан томилолтоор ажилласан.

2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар Геологийн өрөмдлөгийн ажил 3978.6 метр өрөмдлөг хийгдсэн ба ажлын гүйцэтгэл 47.4 хувьтай байна.

II. Арга хэмжээ: 7.4. Тээврийн үйл ажиллагааны санхүү, эдийн засаг, санхүүжилтийн үйл ажиллагааг тээвэр, суурь бүтцийн тарифт тулгуурласан эдийн засгийн тооцоо, гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх.

*Зорилтот түвшин:* IV улирал: Тээврийн үйл ажиллагааны санхүүжилтийн үйл ажиллагааг тээвэр, суурь бүтцийн тарифт тулгуурласан эдийн засгийн тооцоо, гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлсэн байна.

*Хэрэгжилт:* Төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн норм, тарифт нийцүүлэн холбогдох журмын судалгааг хийж, нийт 6 журмын төсөл танилцуулагдаж, хянагдсанаас 2 журам батлагдаж, мөрдөн ажиллаж байна.

Эдийн засгийн болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон өртгийн бүртгэлийн баримт бичигтэй болох ажлын зардлын дүнг шинэчлэн төсвийн тодотголд батлуулж, бэлтгэл ажлыг хангасан.

Гүйцэтгэх захирлын 2023 оны А/51 дүгээр тушаалаар “Суурь бүтэц ашиглуулах, тээврийн үйлчилгээний тариф”-ын тээврийн салбарт өрсөлдөх чадварыг судалж, шинэчлэн санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, үр дүнг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 08/5442 дугаартай албан бичгийн дагуу “Суурь бүтэц ашиглалтын тариф тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэгт “Тавантолгой төмөр зам” ХХК-иас орох ажилтнуудын нэрсийг 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/2217 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

### 3.2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт заалт	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй
		100	90	70	50	30	0	
1	100.0	1	-	-	-	-	-	-

### 3.3 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Эрхзүйн актын нэр	Нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс хэрэгжилтийн хувиар				Хугацаа болоогүй
			100	70	30	0	
Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол	1	100.0	1	-	-	-	-
Дүн	1	100.0	1	-	-	-	-

### 3.4 Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Хэрэгжилтийн дундаж хувь	Тайлант хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан					Хугацаа болоогүй (төрийн тоо)	Оруулах мэдээлэлгүй
					100	90	70	50	30		
1	Төсөв, гүйцэтгэл	13	86.7	4	1	-	-	1	-	-	7
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	6	82.5	3	-	-	-	1	-	-	2
3	Бусад	8	90.0	6	-	-	-	1	-	-	1
Дүн		27	87.0	13	1	-	-	3	-	-	10

### 3.5 Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Хэрэгжилтийн дундаж хувь	Үүнээс /хувиар/					Хугацаа болоогүй	Хамааралгүй
				100	70	30	0			
1	Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	87.5	7	-	-	1	-	2	
2	Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал	6	90	4	2	-	-	-	-	
3	Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	86.7	12	1	1	1	-	-	
4	Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	2	100	2	-	-	-	-	-	
5	Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	12	65.7	4	-	2	1	-	5	
Дүн		45	84.2	29	3	3	3	-	7	

## Дөрөв. Дүгнэлт:

### I. Төлөвлөлтийн байдал

1) "ТТЗ" ХХК 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөхдөө хариуцах газар, хэлтсийн нэр заан тусгаж, яамтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

2) Харин тухайн төлөвлөгөөний 8.3-ын зорилтот түвшинд 1-3-р улиралд хэрэгжүүлнэ гэж заасан байтал хугацаа гэсэн хэсэгт жилийн турш хэрэгжүүлэхээр механик алдаа гаргажээ.

### II. Хэрэгжилтийн байдал:

1. "Тавантолгой төмөр зам" ХХК нь 2023 оны онд нийт 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн үнэлгээтэй 25, 90 хувийн үнэлгээтэй 7, 70 хувийн үнэлгээтэй 2, 50 хувийн үнэлгээтэй 2, 30 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар 90.2 хувьтай үнэлэгдсэн байна.

2. Тайлант хугацаанд төлөвлөсөн 1.1.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээврийн ажлыг оновчтой, аюулгүй зохион байгуулах, 1.2.Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, гэрчилгээжүүлэх, 2.4.Гашуунсухайт-Ганцмод боомтын 7.9 км төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх, 5.3.Тээврийн нэгдсэн цахим программ хангамжийн худалдан авалт, компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, 8.4.Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах гэсэн ажлыг 2 улирал дараалан хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3. Шилэн дансанд байршуулах 27 мэдээллээс тайлант хугацаанд тухайн байгууллагад хамааралтай 17 мэдээлэл байх бөгөөд үүнээс зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ.

4. Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах ажлыг хангалттай хэрэгжүүлээгүй байна.

## Тав. Санал, зөвлөмж

1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан өөрийн байгууллагын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө бүрэн тусгаж, зорилтот түвшнийг ижил төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллах;д

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан боловч хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарч, төлөвлөгөөний биелэлттэй холбоотой төлөвлөгөө түүний хэрэгжилт, холбогдох бусад баримт бичгийг хавсралтаар гарган ирүүлж хэвших;

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход анхаарч байгууллагынхаа үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

4. Шилэн дансанд байршуулдаг мэдээллийг мэдээлэх ажлыг шуурхай гүйцэтгэж, мэдээллийг тогтоосон хугацаанд тухай бүр нь оруулж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж хоёр мянган тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн дүрмийн алдаагүй тайлагнаж хэвших;

6. Тус байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан байгууллагынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг албан бичгээр ирүүлэх;

7. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, төлөвлөлтийг зөв тодорхойлж, ажлаа бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөж байна.



ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ИТГЭЛТ

"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ"  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.БУДБАЯР

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ





ЗАМ, ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

/жилийн эцсийн байдлаар/

д/д	Хяналтад байх арга хэмжээ	2023 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Хэрэгжилт /хувиар/								Хураанаа болгоүй	Хамаралгүй	Оруулах мэдээлгүй
				Дундаж хувь	100	90	70	50	30	0				
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	38	38	90.2	25	7	2	2	2	2	0	-	-	-
2	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	1	1	100.0	1	-	-	-	-	-	-	-	-	-
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	1	1	100.0	1	-	-	-	-	-	-	-	-	-
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	27	17	87.0	13	1	-	-	-	3	-	-	-	10
5	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	45	38	84.2	29	-	3	-	-	3	3	-	7	-
Нийт		112	95	87.4	69	8	5	2	8	3	3	-	7	10